



СҮХБААТАР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ БАЙДЛЫН 2014 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



Баруун-Урт сум
2015 он

Гарчиг

Судалгааны гол агуулга, зорилго4
Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт5-6
Онолын хэсэг7-9
Бүлэг 1. Хүн ам зүйн байдал9
1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт10-12
1.2 Хүн ам, өрхийн тоо, байршлаар, сумаар13-15
1.3 Хүн амын нягтрал, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд15-17
1.4 Хүн амын нас хүйсийн суварга, дундаж наслалт18-19
1.5 Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох хүүхэд, өндөр настай хүний тоо20-21
1.6 Нийгмийн зарим үзүүлэлтүүд22-24
Бүлэг 2. Хүн амын ердийн хөдөлгөөн25-26
2.1 Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт26-27
2.2 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт27-29
Бүлэг 3. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн29
3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал29-30
3.2 Шилжин ирэлт31
3.3 Шилжин явалт32
3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн33
Дүгнэлт34-35
Судалгаанд ашигласан материалын жагсаалт36
Хавсралт хүснэгтүүд37

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН

О.УНДРАХ

Хаяг: Нутгийн удирдлагын ордон, Өрөө 103 тоот

Утас: 70518819, 70518203

Цахим хаяг: sukhbaatar@nso.mn

Веб хаяг: <http://sukhbaatar.ubseg.gov.mn>

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/statistic>

Статистик мэдээллийн нэгдсэн сангийн сайт: www.1212.mn

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Баруун-Урт сум, 2016 он

Судалгааны зорилго:

Сүхбаатар аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн түвшин, Монгол улсын хэмжээнд ямар түвшинд явж байгаа, хүн ам зүйн өсөлт, шилжих хөдөлгөөний хандлага, хүн ам зүйн ачаалал, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшинг сүүлийн 5-8 жилээр харьцуулан тооцож, үнэлэлт дүгнэлт өгөхөд орших ба тус аймгийн удирдлага болон хэрэглэгчдийг хүн ам, өрхийн дэлгэрэнгүй мэдээллээр хангах зорилготой болно. Хүн амын тогтвортой өсөлтийн хангах гол үзүүлэлт бол хүн амын цэвэр өсөлт мөн.

Улсын нийгэм эдийн засгийн хөгжил нь тухайн орны хүн ам зүйн бодлогоо хэрхэн боловсруулж, яаж хэрэгжүүлэхээс шууд шалтгаална.

Хүн амын нас, хүйсийн бүтцийн шинжилгээний хүрээнд хүн амын нас, хүйсийн суварга, хүйсийн харьцаа, хүн ам зүйн ачаалал, насжилтын индекс, өндөр настны индекс зэрэг үзүүлэлтүүдийг ашигладаг. Эдгээр үзүүлэлтүүдийн эцсийн зорилго нь тухайн улс, бүс, орон нутгийн хүн ам залуу/ хөгшин бүтэцтэй эсэх, мөн хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан эсэхийг тодорхойлох явдал юм.

Эдийн засгийн хөгжил нь хүн амын тоо, насны бүтэц, өсөлтийн түвшингээс шууд хамаарч байдаг. Тиймээс хүн амын өсөлт, насны бүтэц, байршил болон түүнд гарч буй өөрчлөлтүүдийг сүүлийн найман жилээр харуулж, харьцуулсан судалгааг хийхийг зорьлоо.

Судалгааны агуулга:

Хүн ам, өрх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон жендерийн асуудлаарх орон нутгийн түвшинд бодлого, хөтөлбөр боловсруулах, төлөвлөлт хийх, хэрэгжилтийг нь үнэлэхэд ашиглах үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилгоор орон нутгийн боловсруулагч нарт зориулж хүн ам, өрхийн сүүлийн 5-8 жилийн дүнд суурилан хүн ам, өрхийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын дагуу хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үр дүнг гаргасан. Судалгааг гаргахын тулд 2010-2015 оны суурин хүн амын жилийн эцсийн тайлан, хүн амын ердийн хөдөлгөөний тайлан, хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан, хүн амын үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага, нийгмийн зарим үзүүлэлтүүдийн мэдээний үзүүлэлтийг ашиглан судалгааг хийлээ.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ:

Суурин хүн ам: Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.

Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Нэг өрхөд ноогдох хүний тоо: Нэг өрхөд ноогдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.

Хүйсийн харьцаа: Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.

Насны голч: Хүн амыг нас бүтцийх нь хувьд яг голлон хувааж байгаа насыг насны голч гэнэ.

Хүн амын нас-хүйсийн суварга: Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсийн ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд: Нөхөргүй, өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

Хотын хүн амд: Улаанбаатар хот, аймгийн төв, тосгонд оршин суугаа хүн амыг хамруулна.

Хөдөөгийн хүн амд: Сумын төв, хөдөө нутагт амьдарч байгаа хүн амыг хамруулна.

Бүтэн ба хагас өнчин хүүхдэд: Эцэг эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчинд, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.

Төрөх үеийн хүйсийн харьцаа: Энэ нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Энэ нь 1000 хүн ам тутамд ноогдох тухайн жилд төрсөн амьд хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 1000-аар үржүүлдэг.

Төрөлтийн тусгай коэффициент: Энэ нь нөхөн үржихүйн нас(15-49)-ны 1000 эмэгтэйчүүдэд ноогдох амьд төрөлтийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

Төрөлтийн нийлбэр коэффициент: Энэ нь нэг эмэгтэй нөхөн үржихүйн нас (15-49)-ныхаа туршид төрүүлэх нийт хүүхдийн тоо.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент: Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцаа

Нас баралтын хүйсийн харьцаа: Энэ нь нас барсан эрэгтэй хүний тоог нас барсан эмэгтэй хүний тоонд харьцуулсан харьцаа юм.

Нас баралтын ерөнхий коэффициент: Энэ нь 1000 хүн ам тутамд ноогдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 1000-аар үржүүлдэг.

Гэрлэлт: Тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид гэр бүл болсноо бүртгүүлсэн хүмүүсийг гэрлэсэнд тооцно.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцааг илэрхийлсэн үзүүлэлт.

Хүүхэдтэй гэр бүлгүй хүн ам: Гэр бүлгүй, 16 хүртэл насны хүүхэдтэй эрэгтэй болон эмэгтэй хүнийг эцэг, эх, хамаатан садангийн хэнтэй амьдарч байгааг харгалзахгүйгээр хамруулж тооцно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо: Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн хамгааллын тухай хуулийн 3-р зүйлд: Бие бялдар оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг, өөрчлөлт, өвчин тарилгын дараах хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун санааны хомсдол, сэтгэгцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон

Монгол Улсын иргэн, Монгол улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэж тодорхойлсон бөгөөд хөдөлмөр магадлах комиссоор тахир дутуу болох нь тогтоогдсон хүнийг авч бүртгэнэ.

ОНОЛЫН ХЭСЭГ

Хүн амын жилийн дундаж тоо:

Тооцох арга зүй: тухайн оны эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тооцно.

$$XA_{(дун)} = \frac{XA_{(ж.эх)} + XA_{(ж.эц)}}{2}$$

$XA_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

$XA_{(ж.эх)}$ - Жилийн эхний хүн амын тоо

$XA_{(ж.эц)}$ - Жилийн эцсийн хүн амын тоо

Улсын хэмжээнд нэг хүнд ноогдох үзүүлэлтийг тооцохдоо хүн амын жилийн дундаж тоог ашиглана. Хүн амын жилийн дундаж тоог ҮСХ-оос мэдээлснээр тооцож авна. Олон жилийн динамик тооцоо хийхэд хүн амын жилийн дундаж тоог ашиглана.

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь:

Тооцох арга зүй: Тайлант оны хүн амын тооноос суурь болгон авсан хүн амын тоог хасч, дээрх 2 оны хоорондох хугацаа болон суурь оны үржвэрт харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЖДӨХ = \frac{XA_{(m)} - XA_{(c)}}{X * XA_{(c)}} * 100$$

$ЖДӨХ$ - Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь

$XA_{(m)}$ - Тайлант оны хүн амын тоо

$XA_{(c)}$ - Суурь оны хүн амын тоо

X - Суурь болон тайлант оны хоорондох хугацаа

Хүн амын ердийн цэвэр өсөлт:

Тооцох арга зүй: Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч тооцно. Төрөлт, нас баралтын тооноос шалтгаалж, энэ үзүүлэлт нь эерэг, сөрөг аль ч байж болно.

$$EЦӨ_{(ХА)} = ТТ - НБТ$$

EЦӨ_(ХА) - Хүн амын ердийн цэвэр өсөлт
ТТ - Төрсөн нийт хүүхдийн тоо
НБТ - Нас барсан нийт хүний тоо

Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралтын коэффициент:

Тооцох арга зүй:Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч, хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ. Төрөлт , нас баралтын тооноос шалтгаалж энэ үзүүлэлт эерэг, сөрөг аль нь ч байж болно.

$$EЦӨK_{(ХА)} = \frac{ТТ - НБТ}{ХА_{(дун)}} * 1000$$


EЦӨK_(ХА) - Хүн амын ердийн цэвэр өсөлт /бууралтын коэффициент
ТТ - Төрсөн нийт хүүхдийн тоо
НБТ - Нас барсан нийт хүний тоо
ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо

Хүн амын нас хүйсийн харьцаа:

Тооцох арга зүй: Суваргын баруун, зүүн талд хүйсээр ялган, насны бүтцийн хувьд хамгийн залуугаас эхлэн өсөх дарааллаар дээш суварган хэлбэртэй байна. Хүн амын нас хүйсийн суваргыг зурахдаа хүн амын бодит тоо болон нийт хүн амд эзлэх хувийн жингээр зурна. Хувийн жингээр зурахдаа нийт хүн амыг 100 хувь гэж үзнэ.

Хүн амын хүйсийн харьцаа:

Тооцох арга зүй: Тухайн оны эрэгтэй хүн амын нийт тоог эмэгтэй хүний нийт тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ.



$$XX = \frac{XA_{(эр)}}{XA_{(эм)}} * 100$$

XX - Хүйсийн харьцаа
XA_(эр) - Эрэгтэй хүн амын нийт тоо
XA_(эм) - Эмэгтэй хүн амын нийт тоо

Хүн ам зүйн ачаалал:

Тооцох арга зүй: Хүүхэд буюу 0-14 нас, хөгшид буюу 65 ба түүнээс дээш настай хүн амын тооны нийлбэрийг хөдөлмөрийн насны хүн ам буюу 15-64 насны хүн амын тоонд харьцуулж, 100-гаар үржүүлж тооцно. Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулинд хөдөлмөрийн насны хүн амын насыг тодорхойлохдоо эмэгтэй 15-55, эрэгтэй нь 15-60 гэж заасан байдаг.

$$ХАЗА = \frac{XA_{(0-14)} + XA_{(65+)}}{XA_{(15-64)}} * 100$$

ХАЗА - Хүн ам зүйн ачаалал
XA₍₀₋₁₄₎ - 0-14 насны хүн амын тоо
XA₍₆₅₊₎ - 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо
XA₍₁₅₋₆₄₎ - 15-64 насны хүн амын тоо

Хүн амын нягтрал:

Тооцох арга зүй: Тухайн оны суурин хүн амын тоог нутаг дэвсгэрийн талбайн хэмжээнд харьцуулж тодорхойлно.

$$XA_{(няг.)} = \frac{XA_{(с)}}{НДХ}$$

XA_(няг.) – Хүн амын нягтрал
XA_(с) - Суурин хүн амын тоо
НДХ - Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ


БҮЛЭГ 1. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ**1.1.Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт**

Сүхбаатар аймгийн суурин хүн ам 2015 оны жилийн эцсийн байдлаар 58.8 мян.хүн болж, 2014 оныхоос 1378 хүн буюу 2.4 хувиар өссөн, мөн 2011 оныхоос 3.7 мян.хүн буюу 6.6 хувиар, 2012 оныхоос 3.1 мян. хүн буюу 5.6 хувиар, 2013 оныхоос 2.4 мян.хүн буюу 4.3 хувиар тус тус өссөн байна. Хэдийгээр хүн амын тооны хувьд ингэж өссөн хэдийч өсөлтийн хурд төдийлөн тогтвортой байж чадаагүй байна. Манай аймгийн хувьд 2011 оноос хүн амын өсөлтийн хурд харьцангуй тогтвортой өсөх хандлагатай байгааг Зураг 1.1 графикаас харж болно.

ХҮСНЭГТ 1.1. ХҮН АМЫН ТОО, ӨРХИЙН ТОО, СУМААР, 2011-2015 ОН

Сум	2011		2012		2013		2014		2015	
	Суурин хүн ам	Өрхийн тоо	Суурин хүн ам	Өрхийн тоо	Суурин хүн ам	Өрхийн тоо	Суурин хүн ам	Өрхийн тоо	Суурин хүн ам	Өрхийн тоо
Ас	1 757	479	1 752	478	1 734	478	1 728	481	1 712	495
Бд	4 605	1 238	4 614	1 244	4 597	1 264	4 747	1 303	4 801	1 331
Да	2 846	792	2 856	807	2 852	828	2 897	844	2 994	871
Мх	4 291	1 230	4 269	1 250	4 295	1 284	4 366	1 291	4 517	1 323
На	1 526	424	1 550	429	1 537	438	1 534	438	1 552	458
Он	3 608	979	3 655	981	3 650	1 002	3 647	991	3 786	1 021
Сү	3 146	875	3 178	909	3 145	919	3 134	916	3 188	938
Тш	3 042	857	3 017	871	3 074	894	3 151	910	3 251	930
Тц	2 386	737	2 391	738	2 342	724	2 360	720	2 398	735
Уб	2 827	798	2 780	793	2 772	801	2 817	816	2 854	832
Ха	1 583	446	1 596	460	1 595	459	1 597	465	1 598	466
Эц	6 474	1 722	6 527	1 741	6 526	1 760	6 549	1 777	6 476	1 821
Бу	17 037	5 190	17 463	5 283	18 228	5 562	18 887	5 727	19 665	6 030
Дүн	55 128	15 767	55 648	15 984	56 347	16 413	57 414	16 679	58 792	17 251

ЗУРАГ 1.1. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, 2008-2015 ОН



Хүн амын өсөлтийг тооцдог математик аргуудаас хамгийн энгийн аргуудын нэг арифметик загварыг ашиглан сүүлийн 8 жилд Сүхбаатар аймгийн хүн ам жилд дунджаар хэдэн хувь өссөн, буурсан тооцоог хийж үзье.

Арифметик загвараар хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооцоход дараах томъёог ашиглана. Үүнд:

$$r = \frac{p_t - p_o}{p_o * n} * 100$$

Энд: P_t –Хугацааны эцэс дэх дундаж хүн амын тоо

P_o –Хугацааны эхэн дэх дундаж хүн амын тоо

n- Тооцоо хийж буй хугацааны интервал

r- Жилийн дундаж өсөлтийн хурд

Сүхбаатар аймгийн дундаж хүн амын тоо 2008 онд 53164 байснаа 2015 онд 58103 болж, 2008-2015 оны хоорондох 8 жилийн хугацаанд хүн ам нь жил тутам дунджаар хэдэн хувиар өссөнийг арифметик загвар ашиглан дараах байдлаар тооцоход:

$$r(2008-2015) = \frac{58103 - 53164}{53164 * (2015 - 2008)} * 100 = 1.3$$

Хүн амын тооны өөрчлөлт арифметик хандлагаар явагдсан гэж үзвэл, 2008 оноос 2015 онуудад жил тутам дунджаар 1.3 хувиар өссөн байна.

Бүрэлдэхүүний аргаар хүн амын өсөлт тооцох-доо хүн ам зүйн тэнцлийн томъёог ашиглана. Энэхүү томъёо нь хүн амын тоо хэмжээнд өөрчлөлт оруулдаг гурван үндсэн үзэгдэл болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний тоон мэдээлэлд үндэслэн хоёр хугацааны хоорондох хүн амын өсөлт, өөрчлөлтийг тооцох арга юм. Хүн амын тэнцлийн томъёо нь:

$$P_t - P_o = (B - D) + (In - Out)$$

Энд, P_t –Хугацааны эцэс дэх хүн амын тоо

P_o –Хугацааны эхэн дэх хүн амын тоо

B–Хугацааны эхнээс эцэс хүртлэх нийт төрсөн хүүхдийн тоо

D–Хугацааны эхнээс эцэс хүртлэх нас баралтын тоо

In–Хугацааны эхнээс эцэс хүртлэх нийт шилжин ирэлтийн тоо

Out–Хугацааны эхнээс эцэс хүртлэх нийт шилжин явалтын тоо

Томъёог бага зэрэг хувиргаж бичвэл:

Хүн амын өсөлт=ердийн цэвэр өсөлт+механик цэвэр өсөлт

Сүхбаатар аймгийн хүн амын өсөлтийн тоог бүрэлдэхүүний аргаар тооцон үзье.

$$\text{Хүн ам}_{(2015 \text{ оны жилийн эцсийн})} = 57414 + 1589 - 349 + 905 - 900 = 58659$$

Дээрх тооцооллоор 2015 оны эхэн үетэй харьцуулахад Сүхбаатар аймгийн хүн амын тоо оны эцэст нийт 1245 хүнээр нэмэгдсэн ба үүний 1240 хүн буюу 99.6 хувь нь ердийн цэвэр өсөлт (төрөлт, нас баралтын зөрүү), 5 хүн буюу 0.4 хувь нь механик цэвэр өсөлт (шилжин ирэлт, явалтын зөрүү)-өөс бий болсон байна.

Хүн амын тэнцлийн томъёогоор тооцсон оны эцсийн хүн амын тоо мэдээлэл нь хүн ам, орон сууцны завсрын тооллогын үр дүнгээр зарлагдсан дүнгээс зөрүүтэй байгаа нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний мэдээллүүдийн аль нэг нь эсвэл мэдээлэл буруу бүртгэлтэй байдагтай холбоотой тайлбарлагдана.

Бүрэлдэхүүний аргаар тооцсон хүн амын өсөлтийн мэдээллийг ашиглан хүн амын өсөлтийг хувь, түвшингээр тооцож болно. Ингэхдээ, хүн амын тэнцлийн томъёоны үзүүлэлтүүдийг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулна. Томъёог дараах байдлаар илэрхийлж болно. Үүнд:

Бүрэлдэхүүний аргаар хүн амын өсөлтийн түвшинг тооцох:

$$\frac{P_t - P_o}{\bar{P}} * k = \frac{B - D}{\bar{P}} * k + \frac{In - Out}{\bar{P}}$$

Хүн амын Ердийн цэвэр Механик цэвэр
өсөлтийн түвшин = өсөлтийн түвшин + өсөлтийн түвшин

Дээрх томъёог ашиглан Сүхбаатар аймгийн хүн амын 2015 оны эхнээс оны эцэс хүртэл хугацааны өсөлтийн түвшинг тооцож үзэхэд:

$$\frac{58659 - 57414}{58103} * 100 = \frac{1589 - 349}{58103} * 100 + \frac{905 - 900}{58103} * 100$$

$$2.14\% = 2.13\% + 0.01\%$$

Сүхбаатар аймгийн хүн ам 2015 оны эхнээс эцэс гэхэд 2.14 хувиар өссөн бөгөөд үүний 2.13 хувь нь ердийн цэвэр өсөлтөөр, 0.01 хувь нь шилжих хөдөлгөөн буюу механик өсөлтөөр бий болжээ.

ХҮСНЭГТ 1.2. ХҮН АМЫН ТОО, БАЙРШЛААР, СУМААР, 2011-2015 ОН

Сум	2011		2012		2013		2014		2015	
	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө
Ас	623	1 134	652	1 100	635	1 099	620	1 108	538	1 174
Бд	1 328	3 277	1 277	3 337	1 199	3 398	1 233	3 514	1 513	3 288
Да	787	2 059	1 013	1 843	1 268	1 584	1 292	1 605	1 758	1 236
Мх	1 215	3 076	1 672	2 597	1 422	2 873	1 449	2 917	1 210	3 307
На	366	1 160	380	1 170	396	1 141	400	1 134	419	1 133
Он	1 225	2 383	659	2 996	1 772	1 878	1 699	1 948	1 265	2 521
Сү	643	2 503	1 101	2 077	1 075	2 070	1 066	2 068	693	2 495
Тш	634	2 408	885	2 132	612	2 462	618	2 533	723	2 528
Тц	1 055	1 331	1 349	1 042	1 184	1 158	1 118	1 242	992	1 406
Уб	741	2 086	981	1 799	1 032	1 740	907	1 910	752	2 102
Ха	592	991	600	996	619	976	628	969	625	973
Эц	2 916	3 558	2 943	3 584	2 938	3 588	2 957	3 592	2 874	3 602
Бу	14 755	2 282	14 917	2 546	15 466	2 762	16 064	2 823	16 668	2 997
Дүн	26 880	28 248	28 429	27 219	29 618	26 729	30 051	27 363	30 030	28 762


Аймгийн суурин хүн ам Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумдад нийт хүн амын 6.4-11.0 хувь нь оршин сууж байгаа бол аймгийн төвийн сум буюу Баруун-Урт суманд 33.4 хувь нь суурьшин амьдарч байна. Нийт хүн амын 51.1 хувь нь аймаг, сумын төвд амьдарч байгаа нь 2014 оныхоос 0.1 хувиар буурсан байна. Сүүлийн жилүүдийн хүн амын тооноос харахад аймаг, сумын төвд амьдарч байгаа хүн жилээс жилд бага зэрэг өсч байсан хэдий ч өнгөрсөн оны мөн үеэс 21 хүнээр буюу 0.1 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ1.3. ӨРХИЙН ТОО, БАЙРШЛААР, СУМААР, НЭГ ӨРХӨД НООГДОХ ХҮНИЙ ТОО, 2011-2015 ОН

Сум	2011		2012		2013		2014		2015		Нэг өрхөд ноогдох хүний тоо
	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	
Ас	187	292	189	289	187	291	183	298	171	324	3.5
Бд	374	864	363	881	349	915	356	947	436	895	3.6
Да	238	554	302	505	382	446	390	454	521	350	3.4
Мх	340	890	495	755	434	850	433	858	357	966	3.4
На	111	313	114	315	117	321	124	314	134	324	3.4
Он	354	625	197	784	491	511	491	500	369	652	3.7
Сү	178	697	298	611	298	621	297	619	206	732	3.4
Тш	180	677	262	609	183	711	176	734	203	727	3.5
Тц	332	405	428	310	378	346	356	364	319	416	3.3
Уб	219	579	285	508	313	488	280	536	235	597	3.4
Ха	169	277	178	282	184	275	189	276	189	277	3.4
Эц	798	924	808	933	813	947	823	954	838	983	3.6
Бу	4 520	670	4 542	741	4 745	817	4 883	844	5 130	900	3.3
Дүн	8 000	7 767	8 461	7 523	8 874	7 539	8 981	7 698	9 108	8 143	3.4

2015 онд нийт өрхийн тоо 17.3 мянга болж 2011 оноос 9.4 хувиар, 2012 оноос 7.9 хувиар, 2013 оноос 5.1 хувиар, 2014 оноос 3.4 хувиар тус тус өссөн байна. 2015 оны нийт өрхийн 52.8 хувь нь аймаг, сумын төвийн өрх, 47.2 хувь нь хөдөөгийн өрх эзэлж байна. 2000-2015 оны хүн амын динамикаас харахад 2000-2006 он хүртэл хүн ам буурч, 2007 оноос аажим, аажимаар өссөн байна. Хөдөө суурьшин мал маллан амьдардаг өрхийн тоо 6.9 мянга болж урьд оноос 4.5 хувиар өссөн ба жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо 2015 онд 14.3 мянга болсон нь 2014 оныхоос 2.9 хувиар өссөн байна. Аймгийн дунджаар нэг өрхийн хүн ам 3.4 байгаа бөгөөд Түмэнцогт, Баруун-Урт, сумдад аймгийн дунджаас цөөн буюу 3.3 хүн, бусад 11 суманд аймгийн дунджаас олон буюу 3.4-3.7 хүнтэй байгаа юм.

ЗУРАГ1.2. ӨРХИЙН ТОО, ЖИЛ БҮРИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР, 2008-2015 ОН



Сүхбаатар аймагт нэг 1 км² нутаг дэвсгэрт 0.71 хүн ногдож байна. Асгат, Сүхбаатар сум нь бусдаас цөөн буюу 0.24-0.25 хүн ногдож байхад аймгийн төв Баруун-Урт суманд хамгийн олон буюу 361 хүн, Түмэнцогт суманд 1.12 хүн, бусад сумдад 0.38-0.75 хүн ногдож байна.

ХҮСНЭГТ 1.4. ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР, 2011-2015 ОН


Сум	Нутаг дэвсгэр, км ² , 2015	Хүн амын нягтрал (1км ² нутаг дэвсгэрт ногдох хүн ам)					2015 / 2014 %
		2011	2012	2013	2014	2015	
Ас	7 198	0.24	0.24	0.24	0.24	0.24	99.1
Бд	7 882	0.58	0.59	0.58	0.60	0.61	101.1
Да	4 814	0.59	0.59	0.59	0.60	0.62	103.3
Мх	7 415	0.58	0.58	0.58	0.59	0.61	103.5
На	3 523	0.43	0.44	0.44	0.44	0.44	101.2
Он	6 468	0.56	0.57	0.56	0.56	0.59	103.8
Сү	12 762	0.25	0.25	0.25	0.25	0.25	101.7
Тш	4 356	0.70	0.69	0.71	0.72	0.75	103.2
Тц	2 135	1.12	1.12	1.10	1.11	1.12	101.6
Уб	4 945	0.57	0.56	0.56	0.57	0.58	101.3
Ха	3 787	0.42	0.42	0.42	0.42	0.42	100.1
Эц	16 948	0.38	0.39	0.39	0.39	0.38	98.9
Бу	54.5	312.61	320.42	334.46	346.55	360.83	104.1
Дүн	82 287	0.67	0.68	0.68	0.70	0.71	102.4

**ХҮСНЭГТ 1.5. ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
СУМААР, 2015 ОН**

Сум	Байнга хүн ам	Үүнээс:		Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал	Дүнд эзлэх хувь	
		Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
Ас	1 712	882	830	106.3	43.6	51.5	48.5
Бд	4 801	2 428	2 373	102.3	50.6	50.6	49.4
Да	2 994	1 494	1 500	99.6	47.3	49.9	50.1
Мх	4 517	2 327	2 190	106.3	50.9	51.5	48.5
На	1 552	791	761	103.9	42.8	51.0	49.0
Он	3 786	1 931	1 855	104.1	50.4	51.0	49.0
Сү	3 188	1 682	1 506	111.7	46.3	52.8	47.2
Тш	3 251	1 669	1 582	105.5	50.0	51.3	48.7
Тц	2 398	1 197	1 201	99.7	47.5	49.9	50.1
Уб	2 854	1 491	1 363	109.4	44.3	52.2	47.8
Ха	1 598	811	787	103.0	43.2	50.8	49.2
Эц	6 476	3 327	3 149	105.7	51.8	51.4	48.6
Бу	19 665	9 706	9 959	97.5	51.7	49.4	50.6
Дүн	58 792	29 736	29 056	102.3	49.6	50.6	49.4


Нийт хүн амын 50.6 хувь нь эрэгтэйчүүд, 49.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзүүлэлтүүд ойролцоогоор хувийн жингээр эрэгтэй, эмэгтэйчүүд 50 хувьд байгаа учир хүйсийн харьцаа ерөнхийдөө тэнцвэртэй, гэхдээ эрэгтэй хүн ам эмэгтэйгээсээ бага зэрэг илүү байна. 100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь сүүлийн жилүүдэд өсч байгаа нь эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсөх хандлагатай байгааг харуулж байгаа юм. Сумдын хүн амын хүйсийн харьцааг харвал Дарьганга, Түмэнцогт, Баруун-Урт сумдад 100 эмэгтэйд 97.5-99.6 эрэгтэй ногдож байгаа бол бусад сумдад 102.3-109.4 эрэгтэй ноогдож байна. Аймгийн хэмжээнд 2015 онд хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 102.3 байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 1.3. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2015 ОН




Зураг 1.3-аас харахад 2015 оны байдлаар Сүхбаатар аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 103 байна гэдэг нь 100 эмэгтэй хүүхэд төрж байхад тэдний цаана 103 эрэгтэй хүүхэд төрсөн байна. Хүйсийн харьцаа 15-50 нас хүртэл 96-110 түвшинд байгаа бол, харин 50-аас дээш насанд 46-96 түвшинд, 100 эмэгтэйд ногдох эрэгтэйн тоо улам багассан буюу зөрүү ихтэй болсон байна. Энэ нь төрөх үед байгалиасаа эрэгтэй хүн ам их төрсөн боловч амьдралын сүүл үед эмэгтэйчүүд их үлдсэн байгааг харуулж байна.

ЗУРАГ 1.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 2008-2015 ОН



2015 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 29.6 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 66.9 хувийг 15-64 насны хүн ам, 3.5 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг. 2013 онд Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангаас гаргасан дэлхийн улс орнуудын залуучуудын бодлогын судалгаанд 198 орон хамрагдсаны 122 улс залуучуудын талаар баримтлах нэгдсэн бодлогын баримт бичигтэй байгаа бол тухайлсан бодлогогүй 76 оронд манай улс багтсан. Тиймээс шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нар залуучуудын хөгжлийн талаар бодлого боловсруулах зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болоод байна.

ЗУРАГ 1.5. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА 2010, 2015 ОН



Хүн амыг насны бүлгээр, хүйсээр, ингэхдээ хүн амын нас, хүйсийн суваргыг зурах сонгодог зарчмын дагуу эрэгтэйчүүдийг зүүн талд нь, эмэгтэйчүүдийг баруун талд нь, насыг доороос дээш өгсөх байдлаар абсолют тоогоор дүрслэн 2010, 2015 оны байдлаар харуулсан болно. Дээрх хүн амын нас, хүйсийн суваргыг харахад дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. Суваргаас харвал хүн ам хүйсийн бүтцийн хувьд ерөнхийдөө тэнцвэртэй боловч ахимаг насанд эмэгтэйчүүдийн тоо 2 дахин илүү, 15-60 насны буюу хөдөлмөрийн насны хүн амын тоо хүүхдүүд болон тэтгэврийн насныхнаас их байгаа нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо нэмэгдсэнээр суваргын суурь хэсэг гадагш тэлсэн байна. 2015 оны байдлаар Сүхбаатар аймгийн хүн ам

ерөнхийдөө идэр, залуу бүтэцтэй, ялангуяа төрөлт нэмэгдсэн байгаа нь ирэх 30-50 жил дотор хүн ам идэр бүтэцтэй, гэрлэх насны болон хөдөлмөрийн насны хүн ам ихтэй байх төлөвтэй бөгөөд түүнээс цааш хэрэв төрөлт буурвал хүн амын дунд настай хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж, насжилт бий болох боломжтой нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 1.6. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, СОНГОСОН ОНУУДААР

Үзүүлэлт	2000	2002	2004	2006	2008	2010	2012	2013	2014
Улсын дундаж									
Үүнээс:	63.2	63.5	64.6	65.9	67.2	68.1	68.7	69.1	69.6
Эрэгтэй	60.4	60.8	61.6	62.6	63.7	64.9	64.9	65.4	65.9
Эмэгтэй	66.1	66.5	67.8	69.4	71.0	72.3	74.3	75.0	75.5
Сүхбаатар	64.3	64.6	65.5	66.7	68.0	68.9	70.8	71.2	71.8

Хүн амын улсын дундаж наслалтыг харвал 2014 онд 69.6 болж өмнөх оныхоос 6.4 пунктээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.5, эрэгтэйчүүдийнх 65.9 болсон байна. 2014 оны байдлаар Сүхбаатар аймгийн дундаж наслалт 71.8 болж улсын дунджаас 2.2 нас, өмнөх оноос 0.6 пунктээр өндөр байна.

Хүн ам зүйн ачааллыг хүүхдийн, хөгшдийн болон нийт ачаалал гэж гурван янзаар тооцож болно. Хүүхдийн ачаалал нь хөдөлмөрийн насны (олон улсын аргачлалаар 15-64 насны хүн амаар тодорхойлогддог) 100 хүнд хэдэн 0-14 насны хүүхдүүд, хөгшдийн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд хэдэн тэтгэврийн насны хүмүүс ногдож буйг харуулдаг. Харин нийт хүн ам зүйн ачаалал нь хүүхдийн болон хөгшдийн ачааллын нийлбэрээр тодорхойлогдоно.

Хүн ам зүйн ачаалал 2015 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 50 хүн ноогдож байна.

ХҮСНЭГТ 1.7. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ 1000 ХҮН АМД НООГДОХ ХҮҮХЭД, ӨНДӨР НАСТАЙ ХҮНИЙ ТОО, СУМААР, 2015 ОН

Сум	Хөдөлмөрийн насны хүн ам	Хүүхэд	Өндөр настан	Бүгд	Хөдөл/насны хүн ам		
					Хүүхэд	Өндөр настан	Бүгд
Ас	1 192	461	59	520	387	49	436
Бд	3 187	1 458	156	1 614	457	49	506
Да	2 033	849	112	961	418	55	473
Мх	2 993	1 348	176	1 524	450	59	509
На	1 087	415	50	465	382	46	428
Он	2 518	1 132	136	1 268	450	54	504
Сү	2 179	919	90	1 009	422	41	463
Тш	2 167	978	106	1 084	451	49	500
Тц	1 626	680	92	772	418	57	475
Уб	1 978	769	107	876	389	54	443
Ха	1 116	416	66	482	373	59	432
Эц	4 267	2 064	145	2 209	484	34	518
Бу	12 960	5 939	766	6 705	458	59	517
Дүн	39 303	17 428	2 061	19 489	443	52	496

Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 66.9 хувийг эзэлж, 29.6 хувийг хүүхэд, 3.5 хувийг өндөр настан эзэлж байна. Хөдөлмөрийн насны 1000 хүнд 443 хүүхэд, 52 өндөр настанг асран тэжээх үүрэг ногдож байна.

Насжилтын индекс:

Насжилтын индекс нь 15 хүртэлх насны 100 хүүхдэд ногдох 65-аас дээш насны хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Үүнийг дараах томъёог ашиглан тооцно.

$$\text{Насжилтын индекс} = \frac{P_{65+}}{P_{0-14}} * 100$$

Сүхбаатар аймгийн 2015 оны эцэст 15 хүртэлх насны хүүхдийн тоо 17428, харин 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо 2061 байгаа бол насжилтын индексийг дараах байдлаар тооцно.

$$\text{Насжилтын индекс} = \frac{2061}{17428} * 100 = 11.8$$

Тооцооллоос харахад, 2015 оны байдлаар 15 хүртэлх насны 100 хүүхэд бүрт ойролцоогоор 65 ба түүнээс дээш насны 12 хүн ногдож байна.

Өндөр настны индекс:

Өндөр настны индекс нь тухайн улс, бүсийн тэтгэврийн насны хүн амын хэдэн хувь нь 80-аас дээш насны өндөр настан байгааг харуулдаг.

$$\text{Өндөр настны индекс} = \frac{P_{80+}}{P_{65+}} * 100$$

Сүхбаатар аймгийн 2015 оны эцэст 65 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо 2061, харин 80 ба түүнээс дээш насны хүн ам тоо 397 байгаа бол өндөр настны индексийг дараах байдлаар тооцно.

$$\text{Өндөр настны индекс} = \frac{397}{2061} * 100 = 19.3$$

Тооцооллоос харахад, 2015 оны байдлаар нийт ахмад настай хүн амын 19.3 хувь нь 80 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

Асран халамжлагчийн харьцаа:

Энэ нь 50-64 насны 100 эмэгтэйд хэдэн 80-аас дээш насны өндөр настан ногдож байгааг харуулдаг. Үүнийг дараах томъёог ашиглан тооцно.

$$\text{Асран халамжлагчийн харьцаа} = \frac{P_{80+}}{P_{\text{эмэгтэй,50-64}}} * 100$$

Сүхбаатар аймгийн 2015 оны эцэст 50-64 насны эмэгтэйчүүдийн тоо 3495, харин 80 ба түүнээс дээш насны хүн амын тоо 397 байгаа бол асран халамжлагчийн харьцааг дараах байдлаар тооцно.

$$\text{Асран халамжлагчийн харьцаа} = \frac{397}{3495} * 100 = 11.4$$

Тооцооллоос харахад 2015 оны байдлаар 50-64 насны 100 эмэгтэй тутамд 80 ба түүнээс дээш настай 11-12 өндөр настан ногдож байна.

ХҮСНЭГТ 1.8. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2010-2015 ОН

Үзүүлэлт	2010*	2011*	2012*	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	207	125	251	404	447	521	116.6
Өрх толгойлсон эх/эцэг гишүүдийн тоо	3 129	3 940	3 765	3 231	3 203	3 233	100.9
Өрх толгойлсон эмэгтэй	1 845	2 118	2 216	2 206	2 125	2 310	108.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	2 248	2 516	2 599	2 663	2 665	2 696	101.2
Үүнээс эмэгтэй:	940	1 115	1 172	1 159	1 107	1 124	101.5
Хагас өнчин хүүхдийн тоо	775	683	696	652	686	654	95.3
Бүтэн өнчин хүүхдийн тоо	52	53	44	40	41	43	104.9

* 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2015 онд 521 буюу нийт өрхийн 3.0 хувийг эзэлж, 2014 оныхоос 16.6 хувиар өссөн байна.

Өрх толгойлсон эх/эцэг гишүүдийн тоо 2015 онд 3233 болж 2014 оныхоос 0.9 хувиар өссөн байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2006-2011 он хүртэл аажмаар өсч, 2012 оноос буурах хандлагатай байсан боловч, 2015 онд 2.3 мянга болж 2010 оныхоос 25.2 хувь, 2012 оныхоос 4.2 хувь, 2014 оныхоос 8.7 хувиар тус тус өссөн байна.

Өнчин хүүхдийн тоо 697 болж, нийт хүн амын 1.2 хувийг эзэлж байна. Энэ нь 2013 оныхоос 0.7 хувиар өсч, 2014 оныхоос 4.1 хувиар буурсан байна.

Бүтэн өнчин хүүхэд нийт хүн амын 0.1 хувь, хагас өнчин хүүхэд 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2015 онд 2696 болж 2012 оныхоос 3.7 хувь, 2013 оныхоос 1.2 хувь, 2014 оныхоос 1.2 хувиар тус тус өссөн байна.

Өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сумдаар нь дараах хүснэгт /хүснэгт1.9./-ээс харж болно. Үүнд:

ХҮСНЭГТ 1.9. ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, СУМААР, 2011-2015 ОН

Сум	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Ас	25	20	38	37	36	97
Бд	58	64	79	72	67	93
Да	26	32	41	39	33	85
Мх	59	59	46	46	46	100
На	13	13	7	13	12	92
Он	47	55	46	48	29	60
Сү	56	42	48	51	47	92
Тш	46	53	49	46	47	102
Тц	32	25	28	31	50	161
Уб	34	48	36	34	28	82
Ха	14	11	5	7	17	243
Эц	129	119	111	122	116	95
Бу	197	199	158	181	169	93
Дүн	736	740	692	727	697	96

Өнчин хүүхдийн тоо 2011-2015 оны хооронд өсөлт, бууралт нь тогтвортой биш байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

2015 онд ихэнх суманд өрх толгойлсон эхийн тоо буурсан боловч зарим суманд өссөний дотор Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Түмэнцогт, Уулбаян сумдад бусдаас илүү буюу 3.1-32.6 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 1.10. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХИЙН ТОО, СУМААР, 2011-2015 ОН

Сум	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Ас	66	66	67	67	72	107.5
Бд	131	104	143	129	133	103.1
Да	85	82	83	80	73	91.3
Мх	210	225	192	195	232	119.0
На	36	43	33	25	25	100.0
Он	65	86	126	123	115	93.5
Сү	96	108	142	135	134	99.3
Тш	111	108	142	140	120	85.7
Тц	148	144	128	132	175	132.6
Уб	107	113	89	90	95	105.6
Ха	50	61	40	51	32	62.7
Эц	221	271	208	207	206	99.5
Бу	792	805	813	751	898	119.6
Дүн	2 118	2 216	2 206	2 125	2 310	108.7

ХҮСНЭГТ 1.11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, 2011-2015 ОН

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	2 516	2 599	2 663	2 665	2 696	101.2
Үүнээс:						
Харааны бэрхшээлтэй	335	367	367	378	385	101.9
Хөдөлгөөний бэрхшээлтэй	646	700	663	715	700	97.9
Хавсарсан	387	154	59	35	93	265.7
Бусад	1 148	1 378	1 574	1 537	1 518	98.8
Эзлэх хувь:						
Харааны бэрхшээлтэй	13.3	14.1	13.8	14.2	14.3	-
Хөдөлгөөний бэрхшээлтэй	25.7	26.9	24.9	26.8	26.0	-
Хавсарсан	15.4	5.9	2.2	1.3	3.4	-
Бусад	45.6	53.0	59.1	57.7	56.3	-

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо жилээс жилд өсч байгаа нь харагдаж байна. 2015 онд 2696 болсны дотор 14.3 хувь нь харааны бэрхшээлтэй, 26.0 хувь нь хөдөлгөөний, 1.3 хувь нь хавсарсан, 57.7 хувь нь бусад бэрхшээлтэй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 1.12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМААР, 2011-2015 ОН

Сум	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Ас	84	79	91	80	79	98.8
Бд	246	285	251	253	242	95.7
Да	94	96	90	101	108	106.9
Мх	133	131	154	148	164	110.8
На	90	89	65	89	78	87.6
Он	184	189	191	199	185	93.0
Сү	53	107	138	153	138	90.2
Тш	153	146	143	145	140	96.6
Тц	111	121	115	102	90	88.2
Уб	96	118	128	127	124	97.6
Ха	80	89	99	100	101	101.0
Эц	288	232	289	295	274	92.9
Бу	904	917	909	873	973	111.5
Дүн	2 516	2 599	2 663	2 665	2 696	101.2

Хөгжлийн бэрхшээлтэй хүн 2015 онд Дарьганга, Мөнххаан, Халзан, Баруун-Урт сумдад 1.0-11.5 хувиар өссөн байна.


БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

2.1. Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт

Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК)-ийг 2003-2015 оны динамикаас харахад 2003 онд 32.7 буюу хамгийн өндөр, 2005 онд 17.6 буюу хамгийн бага байна. 2012 оноос тогтвортой өсч байгаа нь доорх графикаас харагдаж байна. 2015 онд 27.3 болсон нь 2010 оныхоос 5.0 пункт, 2012 оныхоос 2.9 пункт, өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр тус тус өссөн байна.

Нас баралтын ерөнхий коэффициент (НБЕК) сүүлийн 10 жилийн динамик үзүүлэлтээр 2011 онд 8.7 буюу хамгийн өндөр байна. 2015 онд НБЕК 6.0 болсон нь 2012-2014 онуудад 0.4-0.6 пунктээр тус бүр буурсан байна.

ЗУРАГ 2.1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НОГДОХООР, 2010-2015 ОН



**ХҮСНЭГТ 2.1. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
2010-2015 ОН**

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015
Төрсөн хүүхдийн тоо	тоо	1 218	1 494	1 375	1 476	1 540	1 589
Нас барсан хүний тоо	тоо	350	478	357	372	366	349
Цэвэр өсөлт	тоо	868	1 016	1 018	1 104	1 174	1 240
Тухайн жилийн дундаж хүн ам	тоо	54 608	54 990	55 388	55 998	56 881	58 103
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	тоо	15 913	15 869	15 834	15 876	15 817	17 000
Төрөлтийн ерөнхий коэффициент	коэф	22.3	27.2	24.8	26.4	27.1	27.3
Төрөлтийн тусгай коэффициент	коэф	76.5	94.1	86.8	93.0	97.4	93.5
Нас баралтын ерөнхий	коэф	6.4	8.7	6.4	6.6	6.4	6.0
Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент	коэф	15.9	18.5	18.4	19.7	20.6	21.3

2006 оноос эхлэн хүүхдийн мөнгө хөтөлбөр, 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж 2015 онд 1589 болж 2010 оноос 30.5 хувь, 2012 оноос 15.6 хувь, 2013 оноос 7.7 хувь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар тус тус өссөн байна. Нас барсан хүн 2015 онд 349 болсон нь 2011 оноос 129 хүн буюу 27.0 хувь, 2014 оноос 17 хүн буюу 4.6 хувиар тус тус буурсан.

Төрөлт нас баралтыг сумдаар авч үзвэл:

ХҮСНЭГТ 2.2. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, СУМААР, 2011-2015 ОН

Сум	Төрөлт					Нас баралт				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Ас	32	39	38	44	44	9	19	15	9	9
Бд	92	129	103	119	124	27	34	32	37	27
Да	62	63	57	52	74	31	16	20	24	11
Мх	98	139	113	104	100	33	33	25	29	25
На	31	37	42	29	41	12	6	11	8	8
Он	76	103	91	68	86	21	15	20	20	19
Сү	67	101	77	70	94	34	16	20	15	21
Тш	77	89	51	79	87	22	23	19	17	23
Тц	168	165	169	51	63	56	35	19	17	17
Уб	50	56	47	73	56	15	14	16	11	18
Ха	54	90	57	50	39	18	21	13	9	12
Эц	34	38	37	178	166	8	6	48	66	46
Бу	377	445	472	559	566	192	119	114	104	113
Дүн	1 218	1 494	1 354	1 476	1 540	478	357	372	366	349

Хүн амын тоо механик хөдөлгөөнөөс гадна ердийн хөдөлгөөнөөс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Манай аймгийн хувьд 2003 онд 1000 хүнд ногдох төрөлтөөр хамгийн өндөр байсан ба улсын дундажтай харьцуулахад 13.3 промилээр өндөр байжээ. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд 2015 онд 26 болж 2013 оноос 36.8 хувиар өсч, 2014 оноос 3.7 хувиар буурсан байна. 5 хүртэл насандаа эндсэн хүүхэд 2015 онд 6 болсон нь 2013 оноос 14.3 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.


2015 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 788 болж 2013 оноос 21.4 хувиар буурч, урьд оноос 44.9 хувиар өссөний дотор цусан суулга, улаан бурхан, салхинцэцэг, сүрьеэ, тэмбүү, заг зэрэг өвчлөлтүүд голлон нөлөөлсөн.

2.2. Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

Гэрлэлт

Нийт 448 хос 2015 онд гэрлэлтээ бүртгүүлж, 44 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 42 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт урьд оноос 4.9 хувь, үрчлэлт 5.0 хувиар тус тус өсч, гэр бүл цуцлалт 6.4 хувиар буурсан байна.

ЗУРАГ 2.2 1000 ХҮНД НОГДОХ ГЭРЛЭЛТ, 2006-2015 ОН



1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд огцом буурч, 11.6-аас 4.4 болсон бол 2015 онд 7.7 болж урьд оноос 0.2 пунктээр өссөн байна. 1000 хүн амд ногдох гэрлэлт 2003 оноос 2004 онд буурч, харин 2005 онд эргээд өсөх хандлагатай болсон ба 2006 онд “Шинэ гэр бүл бологсод” хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл бологчдод нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэнтэй холбоотойгоор гэрлэлт огцом нэмэгдэж, 2007 оноос буурсан байна. 2015 онд гэрлэлт 448 болсон нь 2006 оноос 67.2 хувь,

2008 оноос 28.2 хувиар тус тус буурч, 2010 оноос 87.4 хувь, 2012 оноос 24.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2.3. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ, 2008, 2010, 2012-2015 ОН

Үзүүлэлтүүд	2008	2010	2012	2013	2014	2015
Гэрлэлт	624	239	360	434	427	448
Цуцлалт	18	20	26	36	47	44
Үрчлэлт	34	51	42	46	40	42
Гэрлэлтийн ерөнхий коэффициент	11.7	4.4	6.5	7.8	7.5	7.7
Гэрлэлтийн тусгай коэффициент	16.1	6.0	9.0	10.8	10.4	10.8


Гэрлэлтийн ерөнхий коэффициент 7.7 байгаа нь ойролцоогоор мянган хүн тутмын 7-8 нь гэрлэснийг харуулж байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2015 онд 2014 оноос 0.2 промилээр өссөн байна.

Гэрлэлтийн тусгай коэффициентээр гэрлэх насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог харуулдаг. 2015 онд 10.8 болж урьд оноос 0.4 промилээр өссөн байна. Өөрөөр хэлбэл гэрлэх насны 1000 хүн тутмаас 10-11 хүн гэрлэсэн байна.

Цуцлалт

Гэр бүл цуцлалт нь хүн амын ердийн хөдөлгөөний бас нэг үзүүлэлт юм.


ЗУРАГ 2.3. 1000 ХҮНД НОГДОХ ЦУЦЛАЛТ, 2006-2015 ОН



1000 хүнд ногдох цуцалсан гэр бүлийн тоо 2015 онд 0.8 байгаа нь 2006 оноос 0.6 промил, 2010 оноос 0.4 промил, 2012 оноос 0.3 промилээр тус тус өсч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад адил түвшинд байна.

Үрчлэлт

ЗУРАГ 2.4. 1000 ХҮНД НОГДОХ ҮРЧЛЭЛТ, 2006-2015 ОН



2015 онд 1000 хүнд ноогдох үрчлэлт 0.72 болж урьд оноос 0.02 промилээр өссөн байна.

БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

Хүн амын шилжих хөдөлгөөөн нь төрөлт, нас баралтын нэг адил хүн амын өсөлт өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уугуул нутгийн хүн амын өөрчлөлтийг газар зүйн нэгжүүдээр тодорхойлж, хүн амын хөдөлгөөнийг судалдаг. Шилжилт хөдөлгөөний түвшинг хэмжихдээ шилжин ирэлтийн коэффициент, шилжин явалтын коэффициент, нийт шилжилтийн коэффициент, цэвэр шилжилтийн коэффициент зэрэг үзүүлэлтүүдийг ашигладаг.

Шилжин ирэлтийн коэффициент (ШИК) нь тухайн орон нутгийн 1000 хүнд ногдох тухайн жилд шилжин ирсэн хүмүүсийн тоог, харин **шилжин явалтын коэффициент (ШЯК)** нь тухайн орон нутгийн 1000 хүнд ногдох тухайн жилд шилжин явсан хүмүүсийн тоог хэлдэг.

$$\text{ШИК} = \frac{\text{Тухайн жилд шилжин ирсэн хүмүүс}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

$$\text{ШЯК} = \frac{\text{Тухайн жилд шилжин явсан хүмүүс}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

ХҮСНЭГТ 3.1. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Сумд	Бүгд	Улаан-баатар	Дорнод	Дорноговь	Бусад	Улаан-баатар	Дорнод	Хэнтий	Дорноговь	Бусад	Бүгд	
Ас	15	14	-	-	1	12	1	-	-	3	16	
Бд	41	14	2	20	5	29	-	5	17	4	55	
Да	28	13	10	2	3	14	6	-	9	3	32	
Мх	89	31	2	15	41	63	10	31	3	6	113	
На	28	10	3	12	3	7	13	2	1	-	23	
Он	25	14	2	7	2	42	7	3	10	-	62	
Сү	27	15	12	-	-	13	6	2	-	1	22	
Тш	68	27	3	8	30	21	2	35	3	1	62	
Тц	51	45	3	-	3	43	1	5	-	5	54	
УБ	43	19	6	6	12	21	2	17	2	4	46	
Ха	6	5	-	-	1	7	1	1	-	-	9	
Эц	75	26	33	3	13	72	14	6	1	5	98	
Бу	409	218	53	29	109	223	27	13	15	30	308	
Дүн	905	451	129	102	223	567	90	120	61	62	900	
Урьд онууд	2014	730	364	84	95	187	736	91	132	83	40	1 082
	2013	778	426	88	73	191	711	119	82	99	102	1 113
	2012	364	217	51	28	68	461	96	57	44	89	747
	2011	530	252	81	69	128	675	121	123	62	187	1 168
	2010	635	314	86	50	185	1 063	90	119	79	69	1 420
2000-2015 онд	5 588	2 685	882	619	1 402	12 171	1 443	2 152	1 419	1 002	18 187	

2015 оны жилийн эцэст 905 хүн шилжин ирж, урьд оныхоос 23.9 хувиар өсч, 900 хүн шилжин явсан нь 16.8 хувиар буурсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 451 хүн буюу 49.8 хувь нь УБ хотоос шилжин ирсэн байна. Шилжин явсан хүн амын байдлаас харахад 63.0 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна.

2000-2015 онуудын нийт шилжин ирэгсдээс Улаанбаатар (48.0%), Дорнод (15.8%), Дорноговь (11.1%), бусад (25.1%) аймгаас ирж суурьшсан, харин шилжин явагсдаас Улаанбаатар хот (66.9%), Хэнтий (11.8%), Дорноговь (7.8%) Дорнод (7.9%), бусад (5.5%) аймгууд руу шилжсэн байна. Сумдаар нь авч үзвэл Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Баруун-Урт зэрэг сумдуудад шилжилт хөдөлгөөн бусад сумдаас өндөр байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2008-2015 ОН



3.2 Шилжин ирэлт

2015 оны жилийн эцсийн байдлаар нийт шилжин ирэгчдийн талаас илүү хувь нь Улаанбаатар хотоос шилжин иржээ. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин ирэлтийн коэффициент юм.

ЗУРАГ 3.2. ШИЛЖИН ИРСЭН ХҮНИЙ ТОО, ШИЛЖИН ИРЭЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, 2008-2015 ОН




Шилжин ирэлтийн коэффициент нь 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо бөгөөд 2007-2010 онд аажмаар өсч, 2011 онд 9.6, 2012 онд 6.6

болж огцом буурсан бол 2013 онд 13.9 болж байна, 2015 онд 15.6 болсон нь өнгөрсөн оноос 2.8 пунктээр өссөн байна.

3.3 Шилжин явалт

2015 оны жилийн эцэст 900 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо бөгөөд 2015 оны эцэст 1000 хүн тутмын 15-16 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2008 оныхоос 11.2 пункт, 2010 оныхоос 10.5 пункт, 2013 оныхоос 4.4 пунктээр тус тус буурсан бол 2012 оныхоос 2.0 пунктээр өссөн байна. Шилжин явалтын коэффициент нь 15.5 болсон нь өнгөрсөн оноос 3.5 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 3.3. ШИЛЖИН ЯВСАН ХҮНИЙ ТОО, ШИЛЖИН ЯВАЛТЫН КОЭФФИЦИЕНТ, 2008-2015 ОН



3.4. Хүн амын нийт шилжилтийн коэффициент (НШК) гэдэг нь тухайн жилийн 1000 хүнд ногдох нийт шилжигчдийн тоог хэлнэ.

$$\text{НШК} = \frac{\text{Шилжин ирэгчдийн тоо} + \text{Шилжин явагчдын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

Сүхбаатар аймгийн 2015 оны байдлаар шилжин ирэгчдийн тоо 905, шилжин явагчдын тоо 900, жилийн дундаж хүн амын тоо 58103 байхад нийт шилжилтийн коэффициентийг тооцвол дараах байдалтай байна.


$$\text{НШК} = \frac{905 + 900}{58103} * 1000 = 31.1$$

Тооцооллоос харахад нийт шилжилтийн коэффициент 31.1 гарсан нь 2015 оны байдлаар Сүхбаатар аймгийн 1000 хүн тутмын 31 нь ирэх/явах хөдөлгөөнд оролцсон хүмүүс байна.

3.5. Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн

Цэвэр шилжих хөдөлгөөн нь шилжих хөдөлгөөний гол үзүүлэлт юм. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент нь (ШХЦК) нь шилжин ирэлтийн коэффициент болон шилжин явалтын коэффициентийн ялгавраар илэрхийлэгдэнэ.

ЗУРАГ 3.4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, 2008-2015 ОН



ШХЦК нь 2008 онд -18.9 байсан бол 2015 онд 0.1 болж буурсан байна. 2008-2015 онуудад Сүхбаатар аймгийн шилжин ирэлт нь шилжин явалтаасаа илүү байна.

ДҮГНЭЛТ

Эдийн засгийн хөгжил нь хүн амын тоо, насны бүтэц, өсөлтийн түвшингээс шууд хамаарч байдаг. Сүхбаатар аймгийн суурин хүн ам 2015 оны жилийн эцсийн байдлаар 58.8 мянгад хүрч, өнгөрсөн оноос 1378 хүн буюу 2.4 хувиар өслөө. Нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 29.6 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 66.9 хувийг 15-64 насны хүн ам, 3.5 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Хөдөлмөрийн насны 1000 хүнд 496 хүүхэд, 52 өндөр настанг асран тэжээх үүрэг ногдож байна. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хурд харьцангуй тогтвортой өсөх хандлагатай байна. 2015 онд хүн ам жилд дунджаар 2.4 хувиар өссөн нь өнгөрсөн оныхоос 0.5 пунктээр өссөн. Нийт хүн амын хувьд 51.1 хувь нь аймаг, сумын төвд амьдарч байгаа нь 2014 оныхоос 0.1 хувиар буурсан байна. Аймгийн суурин хүн ам Баяндэлгэр, Мөнххаан, Эрдэнэцагаан, Баруун-Урт зэрэг сумдуудаар дийлэнх нь суурьшин амьдарч байна.

Харин өрхийн тоо 17.3 мянга болж өнгөрсөн оноос 3.4 хувиар өссөн байна. Нийт өрхийн хувьд 52.8 хувь нь аймаг, сумын төвийн өрх, 47.2 хувь нь хөдөөгийн өрх эзлэж байна. Аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ноогдож байна. 2000-2015 оны динамикаас харахад 2000-2006 он хүртэл хүн ам буурч, 2007 оноос аажим, аажимаар өссөн байна.

Сүхбаатар аймагт нэг км² нутаг дэвсгэрт 0.71 хүн ногдож байна. Хөдөө суурьшин мал маллан амьдардаг өрхийн тоо 6.9 мянга болж урьд оноос 4.5 хувиар өссөн ба жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо 2015 онд 14.3 мянга болсон нь өнгөрсөн оноос 2.9 хувиар өссөн байна.

Нийт хүн амын 50.6 хувь нь эрэгтэйчүүд байна. 100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь сүүлийн жилүүдэд өсч байгаа нь эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна.

Хүн ам зүйн ачаалал 2015 онд хөдөлмөрийн насны 100 хүнд 50 хүн ногдож байна. Хүн амын суваргаас харахад хүн ам, хүйсийн бүтцийн хувьд ерөнхийдөө тэнцвэртэй боловч ахимаг насанд эмэгтэйчүүдийн тоо 2 дахин илүү, 15-60 насны буюу хөдөлмөрийн насны хүн амын тоо хүүхдүүд болон тэтгэврийн насныхаас их байгаа нь харгадаж байна. Мөн 20-34 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг харуулж байна.

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2015 онд 521 буюу нийт өрхийн 3.0 хувийг эзэлж, 2014 оноос 16.6 хувиар өссөн байна.

Өрх толгойлсон эх/эцэг гишүүдийн тоо 2015 онд 3233 болж 2014 оныхоос 0.9 хувиар өссөн байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2015 онд 2.3 мянга болж 2010 оныхоос 25.2 хувь, 2012 оныхоос 4.2 хувь, 2014 оныхоос 8.7 хувиар тус тус өссөн байна.

Өнчин хүүхдийн тоо 697 болж, нийт хүн амын 1.2 хувийг эзэлж байна. Энэ нь 2013 оныхоос 0.7 хувиар өсч, 2014 оныхоос 4.1 хувиар буурсан байна.

Бүтэн өнчин хүүхэд нийт хүн амын 0.1 хувь, хагас өнчин хүүхэд 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2015 онд 2696 болж 2012 оныхоос 3.7 хувь, 2013, 2014 онуудыхаас тус бүр 1.2 хувиар тус тус өссөн байна. Төрлөөр нь ангилан үзэхэд 14.3 хувь нь харааны бэрхшээлтэй, 26.0 хувь нь хөдөлгөөний, 1.3 хувь нь хавсарсан, 57.7 хувь нь бусад бэрхшээлтэй хүмүүс байна.

2006 оноос эхлэн хүүхдийн мөнгө хөтөлбөр, 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж, 2015 онд 1589 болж 2010 оноос 30.5 хувь, 2012 оноос 15.6 хувь, 2013 оноос 7.7 хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар тус тус өссөн байна.

Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд 2015 онд 26 болж 2013 оноос 36.8 хувиар өсч, 2014 оноос 3.7 хувиар буурсан байна. 5 хүртэл насандаа эндсэн хүүхэд 2015 онд 6 болсон нь 2013 оноос 14.3 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

2015 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 788 болж урьд оноос 44.9 хувиар өссөний дотор цусан суулга, улаан бурхан, тэмбүү, салхинцэцэг, сүрьеэ, заг зэрэг өвчлөлтүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт 448 хос 2015 онд гэрлэлтээ бүртгүүлж, 44 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 42 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт урьд оноос 4.9 хувь, үрчлэлт 5.0 хувиар тус тус өсч, гэр бүл цуцлалт 6.4 хувиар буурсан байна.

2015 оны жилийн эцэст 905 хүн шилжин ирж, урьд оныхоос 23.9 хувиар өсч, 900 хүн шилжин явсан нь 16.8 хувиар буурсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 451 хүн буюу 48.0 хувь нь УБ хотоос шилжин ирсэн байна. Шилжин явсан хүн амын байдлаас харахад 567 хүн буюу 63.0 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна.

Танилцуулгын боловсруулсан арга зүй:

Статистикийн албан ёсны мэдээ, тайланд тулгуурлан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, өмнөх онуудтай харьцуулан дүгнэж, статистикийн хүснэгт, зургаар харуулж танилцуулгыг хийлээ.

Хамруулсан хугацаа:

Үзүүлэлтүүдийг ихэвчлэн 2010-2015 оноор, зарим шаардлагатай үзүүлэлтийг 2000-2015 оны байдлаар авч өсөлт өөрчлөлтийг харьцууллаа.

Мэдээллийн эх үүсвэр:

- Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн тайлан (НЗҮ-1)-2015 он
- Аймгийн Статистикийн бюллетень-2015 он
- Статистикийн салбарт мөрдөж ажиллах аргачлалын эмхтгэл
- Хүн амын үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага 2015
- Хүн амын ердийн хөдөлгөөн болон механик хөдөлгөөний мэдээ

ХАВСРАЛТ 1.1 СУУРИН ХҮН АМ /бүгд/

/2015 оны эцэст, насны бүлгээр/

Сумд	Бүгд	Насны бүлгээр											
		0-4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Баруун-Урт	19 665	2 665	454	476	393	338	296	257	262	251	265	282	270
Асгат	1 712	182	36	39	33	26	24	17	35	31	21	17	25
Баяндэлгэр	4 801	573	96	103	102	93	76	76	71	101	78	89	83
Дарьганга	2 994	334	56	65	46	41	45	46	46	59	56	55	58
Мөнххаан	4 517	556	93	76	75	91	90	73	81	66	77	70	83
Наран	1 552	187	33	29	23	23	17	13	18	21	23	28	32
Онгон	3 786	462	87	87	70	54	51	73	48	56	78	66	72
Сүхбаатар	3 188	395	55	72	49	57	49	41	53	50	50	48	61
Түвшинширээ	3 251	421	75	69	60	61	49	48	52	43	53	47	70
Түмэнцогт	2 398	284	54	42	36	37	43	29	45	35	37	38	50
Уулбаян	2 854	312	69	50	63	49	35	32	40	39	41	39	38
Халзан	1 598	201	25	27	28	10	16	18	19	17	18	37	30
Эрдэнэцагаан	6 476	824	146	137	123	148	127	114	116	106	118	105	117
Дүн	58 792	7 396	1 279	1 272	1 101	1 028	918	837	886	875	915	921	989

Сумд	Насны бүлгээр													
	16	17	18	19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60+	
Баруун-Урт	294	264	249	254	1 657	2 072	1 694	1 486	1 200	1 162	993	827	1 304	
Асгат	21	36	29	35	173	133	147	129	120	123	89	82	109	
Баяндэлгэр	84	94	62	93	445	417	406	390	344	273	216	188	248	
Дарьганга	61	60	51	58	262	256	224	266	230	184	162	97	176	
Мөнххаан	76	95	82	77	405	434	377	400	291	241	193	156	259	
Наран	18	31	25	28	142	137	126	125	113	107	97	69	87	
Онгон	71	76	62	64	329	285	318	318	303	225	172	147	212	
Сүхбаатар	62	63	59	58	305	290	265	252	210	200	182	113	149	
Түвшинширээ	80	68	49	72	296	305	288	268	207	159	131	107	173	
Түмэнцогт	48	40	45	44	221	183	180	196	148	148	134	128	153	
Уулбаян	38	52	57	51	271	274	257	216	201	179	156	127	168	
Халзан	36	33	32	24	146	130	120	126	148	119	76	61	101	
Эрдэнэцагаан	137	140	122	105	599	601	570	513	415	300	270	247	276	
Дүн	1 026	1 052	924	963	5 251	5 517	4 972	4 685	3 930	3 420	2 871	2 349	3 415	

